



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/83

Мандалговь

“Мандах бадрах булаг” ХХК-тай гэрээ
байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”- 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн А/06 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Багийн Засаг дарга нарын албан хэрэгцээнд мотоцикл нийлүүлэх” ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Мандах бадрах булаг” ХХК-тай 30,000,000 (гучин сая) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан техникийн үзүүлэлтийн дагуу “Багийн Засаг дарга нарын албан хэрэгцээнд мотоцикл нийлүүлэх” ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Мандах бадрах булаг” ХХК-ны захирал (Ч.Цог-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Төрийн, захиргааны удирдлагын хэлтсийн дарга (М.Цогзолмаа), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА Ц.ЭРДЭНЭСҮРЭН



48206033